

МОНГОЛ ДАХЬ БУРХАНЫ ШАШНЫ ХОЖУУ ДЭЛГЭРЭЛТИЙН ҮЕД ХАМААРАХ “ДОВЖОО-1” ХЭМЭЭХ ДУРСГАЛЫН ТУХАЙ

У.ЭРДЭНЭБАТ, Б.БАТДАЛАЙ, Ч.АМАРТҮВШИН

МУИС, ШУС, Антропологи, Археологийн тэнхим, Археологийн судалгааны төв,
e-mail: u_erdenebat@num.edu.mn; bbatdalai@gmail.com; amartuvshin.ch@num.edu.mn;

ТҮЛХҮҮР ҮГ: Монголын археологи, хот суурины дурсгал, XVI-XVII зууны Монголын сүм хийд, Монгол оронд Бурханы шашин дэлгэрсэн хожуу дэлгэрэлтийн үе

ТОВЧ АГУУЛГА: Монгол Улсын Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Дэлгэрхаан уулын орчим хэлбэр хэмжээ, зохион байгуулалтын хувьд хоорондоо адил төстэй, ойролцоо цаг үеийнх болов уу гэмээр хот суурины зургаан дурсгал бий. 2018 оны 6 дугаар сард Монгол-Америкийн хамтарсан “Дорнод Монгол: Археологийн хайгуул, малтлага судалгаа” төсөл, МУИС-ийн Антропологи, Археологийн тэнхимийн оюутны дадлагын хүрээнд Тогоотын голын баруун эрэгт орших “Довжоо-1” дурсгалыг малтан шинжилж, холбогдох он цагийг тодорхойлох судалгаа хийж гүйцэтгэсэн юм. “Довжоо-1”-ийн тавцангийн баруун хойд буланд орших багавтар барилгын үлдэгдлийг малтахад барилгын дээврийн чимэглэл, вааран хавтангийн хагархай, зээбад, цэцэг ургамлын дүртэй нүүр болон үзүүрийн ваар, модон хийцийн үлдэгдэл, төмөр хадаас, будагтай шаваасны хэсгүүд, хятад зоос, шавар сав, шаазангийн хагархай зэрэг олдворууд гарсан. Мөн барилгын дотор талаас өнгө хориуулан будсан шавар бурханы дүрс баримлын үлдэгдэл, бадам сэнтийн хэсгүүд олдсоноос үзэхэд, нутгийнхны “Сүмийн довжоо” хэмээн нэрлэж ирсэн уг байгууламж нь Буддын шашны тахил шүтээний газар буюу сүм хийдтэй холбоо бүхий дурсгал болох нь илэрхий болсон билээ. “Довжоо-1”-ийн малтлагаас гарсан модон хийцийн үлдэгдлээс дээж авч АНУ-ын Жорж Их Сургуулийн Изотопын судалгааны лабораторид C14 он цаг тогтоох шинжилгээ хийлгэхэд дурсгалын үнэмлэхүй насыг 1497 (2.1%) 1506 calAD; 1512 (71.3%) 1601 calAD; 1616 (22.0%) 1646 calAD буюу нийтийн тооллын XVI-XVII зууны хоорондох цаг үед холбогдохыг тогтоож өгөв. Энэ нь чулуун өрлөгтэй уг барилгын хийц загварын онцлог, шавар чимэглэлийн нь хэв маяг, тоосгон материалын шатаалт, чанар зэргээр бидний таамаглаж байсан он цагийн баримжаатай нийцэж байна.

U. ERDENEBAT, B. BATDALAI, CH. AMARTUVSHIN

ON THE “DOVJOO-1” SITE FROM THE LATE BUDDHIST PERIOD IN MONGOLIA

KEYWORDS: Mongolian archaeology, settlement site, 16-17 c religious centers in Mongolia, later stage of Buddhism spread in Mongolia

ABSTRACT. Six settlement sites that appear to have similar chronology, size, and make-up have been recorded near Delgerkhaan Mountain in Tuvshinshiree sum of Sukhbaatar aimag, Mongolia. Researchers of the Mongolian - American collaborative project “Eastern Mongolia: archaeological survey and excavation”, as well as the field school students from the Anthropology and Archaeology Department, the National University of Mongolia

conducted initial investigations at the site of “Dovjoo-1” on the western bank of Togootyn River in June, 2018 and produced first chronology of the site.

Excavation was conducted on the northern end platform of “Dovjoo-1” site in an area of 10 by 10 meters. From it, we have discovered remain of an old structure measuring 450 by 450 cm. The foundation of this building was made of flat granite stones put together using natural clay. Many parts of the building as well as other smaller finds were recovered as a result of excavation. These included decorative parts of the building, roof tiles, front and edge decorative tiles with a shape of flowers, fragments of wooden objects, ceramic sherds, iron nails, fragments of porcelain vessel, and old Chinese coins. The internal area of the building yielded fragments of small Buddha figurines. Locals have been traditionally referring to this particular location as “Sumiin Dovjoo” (Monastery doorsteps) which is additional indication of its association with Buddhism.

C14 dating of wood samples from the construction made in the Isotope Research Laboratory at the University of Georgia shows the date of “Dovjoo-1” as 1497 (2.1%) 1506 calAD; 1512 (71.3%) 1601 calAD; 1616 (22.0%) 1646 calAD or roughly between 16th and 17th centuries AD. This has proven our initial chronological prediction that was based on types of finds and other tangible features associated with the building, including the stone foundation build, firing techniques applied to make construction bricks, as well as their quality. In other words, the “Dovjoo-1” site by the Togootyn River in Altatyn Valley has shown to be a site belonging to the later stages of spread of Buddhism in Mongolia. This period is contemporary with the beginning stages of Tumed’s Altan Khan’s reign (1507-1582) who, by sending an official note to Sodnomjamts of Gelugvan in Tibet and appointing him as “Dalai Lama”, had ordered the creation of Shireet Zuut in Khukh Khot. At the same time, Abtai Sain Khan (1534-1586) of the Khalkha made an official visit to Dalai Lama III and built the Erdene Zuu monastery shortly after. After these events, Buddhism, and particularly the Gelugvan branch, has significantly spread throughout Mongolia. Many new religious centers were subsequently built to service the locals, one of which is presumed to be “Dovjoo”.

Монгол-Америкийн хамтарсан “Дорнод-Монгол: Археологийн хайгуул, малтлага судалгаа” төсөл нь Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Дэлгэрхаан уулын орчим доктор Ч.Амартүвшин, профессор У.Ханичёрч нарын удирдлагаар археологийн нарийвчилсан хайгуул, малтлага судалгааны ажлыг амжилттай зохион явуулж байгаа билээ. Тус төслийн 2018 оны хээрийн шинжилгээний хүрээнд Түвшинширээ сумын нутаг Тогоотын голын Довжоо¹ хэмээх газар МУИС-ийн ШУС-ийн Антропологи, Археологийн салбарын оюутны археологийн хээрийн дадлагыг доктор, дэд профессор У.Эрдэнэбат, докторант Б.Батдалай нарын удирдлагаар хийж гүйцэтгэсэн юм (Эрдэнэбат, Батдалай 2019: 295-301).

Умард өргөргийн N 46⁰40’06.3”, дорнод уртрагийн E 111⁰50’47.7” солбицолд, далайн түвшнээс дээш 1088 м өндөрт, Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын 4-р баг буюу Дэлгэрхаан багийн нутагт, сумын төвөөс хойш 52 км зайтай Тогоотын голын баруун эрэгт “Довжоо-1” хэмээх эртний хулширсан турь бий (Зураг 1). Энэ орчим Сүхбаатар аймгийн Түвшинширээ, Мөнххаан, Уулбаян сумдын зааг нутаг гэх бөгөөд Дэлгэрхаан уулын урд, баруун биеэр Түвшинширээ, хойд талаар Мөнххаан, зүүн биеэр Уулбаян сумын малчид нутагладаг.

¹ Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Дэлгэрхаан уулын орчимд нутгийнхны “Довжоо” хэмээн нэрлэдэг зургаан дурсгал бий. Эрдэм шинжилгээний хүрээнд эдгээрийг ялгах үүднээс дугаар өгсөн бөгөөд Тогоотын голынхыг “Довжоо-1” хэмээн нэрийдэв.

“ДОВЖОО-1” ХЭМЭЭХ ДУРСГАЛЫН ТУХАЙ

Тогоотын гол нь одоо жаахан газраа л устай, ихэнх хэсэг нь хатсан сайр болсон бөгөөд хоёр талдаа хадтай тэгш өндөрлөгийн хооронд байх дэрстэй хоолойгоор урсаж байжээ. Тогоотын голын баруун дэнжид байх хүрлийн үеийн дурсгал бүхий Улаан Зуух гэдэг газраас хойш Довжоо-1 хүртэл 3,5 км зайтай. Хатсан сайрын баруун эрэгт ойр орших тэгш боржин хадтай намхан толгой дээрх шороо чулуу ашиглан үйлдсэн дөрвөлжин тавцан юм.

Довжоо-1 нь ерөнхий тэнхлэгээр яльгүй баруун хойш чиглэсэн 1,5 м орчим өндөр, суурь нь хойш урагш 39 м, баруун зүүнш 36 м, тавцангийн дээд хэсгээр хойш урагш 34 м, зүүн баруунш 31 м хэмжээтэй (Зураг 2). Довжоо нь урд талдаа тавцангийн дээр гарч буудаг шаттай байсан бололтой. Тавцангийн буланд цухуйсан чулуун өрлөгийн захыг үзэхэд орчны уул хаданд элбэг байх тэгш хагаралтай хавтгай чулууг сонгон авчирч засаж янзлалгүй эвээр нь тааруулан өрж завсар зайнд нь шороо дүүргэн чигжиж чулуун өрлөгүүдийг үелэн шавар зуурмаг дээрээс нь түрхэж тэгшилж засаж хийсэн шинж тэмдэг мэдэгдэнэ.

Хээрийн шинжилгээний ангийн тэмдэглэлд “Довжоо-1” хэмээн тэмдэглэсэн Тогоотын голын энэхүү хиймэл довжоон дээр байгалийн чулуун материалаас гадна болхи хийцтэй хөх тоосгоны хагархай, дээврийн ваарны хагархай цөөнгүй үзэгдэнэ. Энэ нь уг довжоо ямар нэгэн байшин сууринтай холбоотой болохыг харуулж буй шинж тэмдэг бөгөөд нутгийн ардууд энэ турийг бас “Сүмийн довжоо” гэж нэрлэдэг байна.

Дэлгэрхаан уулын орчим иймэрхүү хэлбэр хэмжээ, зохион байгуулалтын хувьд хоорондоо адил төстэй, ойролцоо цаг үеийнх болов уу гэмээр зургаан “Довжоо” бий. Гэвч тэдний алиныг нь ч урьд өмнө археологийн үүднээс малтан судалж байсангүй, эрдэм шинжилгээний үүднээс холбогдох он цаг, үүрэг зориулалтыг нь тодорхойлсон зүйл байхгүй болно. Харин 1969 онд тус бүс нутагт ажилласан “Гурван голын шинжилгээний анги” /Х.Пэрлээ, Д.Наваан/ Бүрэнцогтын гянт болдын уурхайгаас холгүй орших Төрөн Тогоотын голын баруунаа байгаа Бичигт улаан хадны уйгуржин монгол бичгийн дурсгалуудыг судлах явцдаа, гахай жилийн хаврын эхэн сарын 15-наа бичсэн нэгэн бичээсийг, “Төгүрэнги ханхар газрын тура зохиов” хэмээн уншиж, энэ тура- гэсэн үг бол, эндээс холгүй орших Алтатын хөндийд байгаа Довжоон гэдэг эртний хотын турь байж болох юм, юу ч болсон уул бичиг Монголын эзэнт гүрний (XIII-XIV зуун) үед холбогдоно гэж үзэж байсан ажээ (Наваан 1970: 36-37).

Довжоо-1 дээр түүний баруун хойд буланд нэг, зүүн талын төв зах хэсэгт нэг, тус тус чулуун өрлөгтэй барилга байгууламж байсан нь маш их эвдэгдэж, хэн нэгэн этгээд голд нь хонхойлон ухаж шороо чулууг овоолон орхисон ажээ. Довжоон дээр үүнээс өөр барилга байгууламжийн ором тодорхой мэдэгдэхгүй боловч тавцангийн төв болон хойд хэсгээр тэгш хэмтэй, нэг шугаманд газар шигтгэсэн чулуун өрлөг бий. Гэвч энэ нь барилгын суурь гэхээс илүү уг хиймэл шороон тавцанг бат бэх болгох гэж хүчитгэж тавьсан чулуу бололтой.

Бид энэ удаа Довжоо-1-ийн баруун хойд буланд буй шороо, чулуу холилдсон 90 см орчим овгор нурангийг сонгон түүний зохион байгуулалт, хэдий үед ямар зориулалтаар ашиглаж байсан зэргийг мэдэх, он цаг тогтоох шинжилгээний дээж материал олох зорилгоор 2018 оны 6 сарын 14-нээс 21-ны хугацаанд сорилтын малтлага зохион явуулав. Эхлээд Довжоо-1-ийн баруун хойд буланд орших байгууламжийн гадуур хойд-урд, зүүн-баруун чиглэлээр 10 x 10 м хэмжээтэй талбай үүсгэн түүний

голоор хойд-урд зүгт тэнхлэг татаж өнгөн хөрсний цэвэрлэгээ хийв. Чингэхэд чулуу, шороо, тоосгоны хагархайн нурангийн төв хэсгээс 450 х 450 см хэмжээтэй, байгалийн хавтгай боржин чулуугаар өрсөн зузаан ханатай, чулуун өрлөгийн завсар зайг шавардсан багавтар барилгын ханын үлдэгдэл илрэн гарсан (Зураг 3). Барилгын ханыг орчны уул хаднаас зөөж авчирсан хавтгай боржин чулуугаар хоёроос гурван эгнээ зэрэгцүүлэн давхарлаж өрж хийсэн ажээ.

Баруун ханын үлдэгдэл 70 см зузаан, урт нь барилгын гадна талаар 450 см, тасалгааны дотор 350 см, хойд ханын үлдэгдэл 80 см зузаан, урт нь барилгын гадна талаар 450 см, тасалгааны дотор талд 300 см, зүүн ханын үлдэгдэл 75 см зузаан, урт нь барилгын гадна талаар 450 см, тасалгааны дотор 350 см хэмжээтэй байв. Урд хананд барилгын хаалга байсан бололтой. Маш их эвдэгдэж, өрлөг нь нурсан байлаа.

Барилгын ханыг хийхдээ чулууны хэлбэр хэмжээг сайхан тааруулж давхарлаж өрсөн бөгөөд чулуу хоорондын завсар зайг шар шавраар чигжиж шавардсан ажээ. Өрлөгийн чулууг давхарлах бүр завсар нь ийм шаваас хийсний зэрэгцээ ханын гадна дотно хоёр эгнээний голын өрлөгийн чулууны завсар зайд болхи хийцтэй, шатаалт муутай хөх тоосгоны хагархайг чигжээс болгон ашиглажээ. Хөх тоосгоны хагархайг үзэхэд дотор тал нь хэт шатаж хар өнгөтэй болсон, хэврэг бутрамтгай тоосго байв. Ялангуяа бараг бүхэлдээ эвдэрсэн урд хаалганы ханын өрлөгийг цэвэрлэх явцад тэндээс ийм хөх тоосгоны хагархай, мөн дээврийн ваарны жижиг хагархай хэсгүүд гарч байлаа.

Барилга нь 70-80 см зузаан чулуун ханатай. Гонзгой дөрвөлжин хэлбэртэй. 350х300 см буюу 10,5 м² хэмжээтэй, ганц тасалгаатай аж. Тасалгааны дотор болон барилгын чулуун ханын гадна талаар өрлөг чулуу, ваарласан дээвэр нь нурж нуранги нь эмх замбараагүй хөглөрөн овоорч элс шороонд дарагджээ. Бид өнгөн хөрсний цэвэрлэгээгээр мэдэгдсэн дөрвөлжин ханын өрлөгийг дагуулан тасалгааны дотор талд нурангийг цэвэрлэж ажиллав. Малтлагын явцад барилгын тасалгааны зүүн урд болон зүүн хойд булангаас тус бүр 1 ширхэг, дугуй товруун толгойтой хүрэл хадаас, хөх хуартай хятад шаазангийн хагархай, дэгээ маягийн толгойтой жижиг төмөр хадаас, ямар нэг юмны хүрээ гуу мэт дөрвөлжин хэлбэртэй гуривтай төмөр эдлэл олдсон. Мөн мэрэгч амьтны нүхээр зөөгдөн орсон бололтой бог малын ясны жижиг хэсгүүд, мэрэгчийн яс гарч байлаа.

Барилгын чулуун ханын үлдэгдлийн хамгийн дээд талын чулуун өрлөг мэдэгдэж байгаа түвшнээс доош 80 см гүнд барилгын тасалгааны баруун хойд булангаас дагтаршуулсан шавар шал илрэв. Энэ хэсгээс мөн модны жижиг үйрмэг, улаан өнгийн будагтай ханын шаваасны хэсгүүд олдсон. Будагтай ханын шаваасын дийлэнх нь тод улаан өнгөтэй, зарим цөөн нь ногоон будагтай байв. Бид дагтаршуулсан шавар шал байгаа шинж тэмдэг мэдэгдсэн түвшинд барилгын тасалгааны дотор талын бүх нурангийг зайлуулж цэвэрлэв. Малтлагын явцад тасалгааны төв ба баруун хойд хэсэгт шалыг доош цөмлөж ухсан тонуулчдын нүхний толбо байгаа нь тодорхой мэдэгдэв. Мөн барилгын дотор талд тасалгааны зүүн урд булангаас улаан, ногоон, алтан шар, цагаан өнгөөр өнгө хоршуулан будсан бурханы шавар сэнтийн хэсэг бололтой бадмалянхуа цэцгийн дэлбээ дүрсэлсэн будагтай шаврын жижиг хэсгүүд олдсон. Будагнаас пигментийн найрлагын шинжилгээ хийх дээж авав. Мөн жижиг мод, малын яснаас он цаг тогтоох дээж авлаа.

Ханын шаваас 2-5 см зузаан, шохой болон элдэв сүрэл, ургамлын хольц байхгүй дан шар шавраар хийсэн ажээ. Барилгын дотор ханын зарим хэсэг, бас танхимд байсан бурхан тахилын ширээний шаваасыг гол төлөв улаан будгаар будаж чимэглэсэн байжээ. Гэвч ийм будагтай шаваас ханын өрлөгөн дээр ер хадгалагдаж үлдсэнгүй, цөм нурангин дотроос хагарч бутарсан, хэсэг бусаг байдлаар олдлоо. Ханын шавааснаас гадна бас түүхий шавраар хийсэн бурханы сэнтийнх бололтой бадамлянхуа цэцгийн дэлбээний хагархай хэсэг, болхи хийцтэй, муу шатаасан барилгын шавар чимэглэлийн хэсгүүд олдов.

Бурханы сэнтийн дээр өнгө алаглуулан зурсан улаан, ногоон будаг өнгөө тун сайхан хадгалсан, зарим хэсэгт улаан будган дэвсгэр дээр алтан боронзоор зурсан байжээ. Мөн бурхан багшийн шавар шуумалын “үснэр” хэмээх, түүхий шавраар хийсэн ороомог хэлбэртэй шовгор үсний дүрс 3 ширхэг олдлоо. Эдгээр баримтаас үзвэл, нутгийнхны “Сүмийн довжоон” хэмээн нэрлэж ирсэн уг байгууламж буддын шашны тахил шүтээний газар байсан нь ойлгомжтой болов. Харин энд үлдсэн барилгын чимэглэл хэсэг бусаг, бүтэн үлдсэн бүрэн дүрслэлтэй зүйл ховор байгаа тул урлагийн стилийн хувьд он цагийг баттай хэлэх боломжгүй болно. Малтлагаас шавар сав суулганы хагархай маш цөөн гарсан. Хүрэн улаан өнгөтэй, болхи хийцтэй, хээгүй шавар ваарны хагархай, хойд ханын хэсэг ба зүүн урд булангийн малтлагаас хөх хуартай хятад шаазангийн хагархай, хүрэн паалантай савны нимгэн амсрын эмтэрхий зэрэг цөөн зүйл олдов.

Бид барилгын өрлөг чулуу нь бараг бүхэлдээ нурж эвдэрсэн урд ханын суурийн үлдэгдлийг олох, мөн тэнд байсан хаалганы зохион байгуулалтыг ойлгох зорилгоор малтлагыг үргэлжлүүлэн явуулахад тасалгааны зүүн урд булангаас ялзарсан модны жижиг хэсэг, дээрээ улаан, ногоон будагтай ханын шаваасны хагархай хэсгүүд, улаан ногоон өнгөөр дугуй хүрэн дотор цэцэг дүрсэлсэн шавар чимэглэлийн хагархай, хятад үсэгтэй хүрэл зоос 1 ш олдов.

Хэрэв тасалгааны дотор талын нурангийг малтах явцад барилгын чимэглэл болон бусад эд өлгийн зүйл маш цөөн олдож байсан бол урд ханын нурангийг цэвэрлэх явцад уг барилгын хийц чимэглэлийг тодруулах зарим сонирхолтой материал илэрсэн юм. Хаалга байрлаж байсан урд тал нь барилгын бусад хэсгийг бодвол илүү нүнжигтэй чимэглэгдсэн байжээ. Урд ханын хаалганы хоёр талаас бадамлянхуан дэлбээ ба үрлэн хээг товойлгон дүрсэлсэн тоосгон чимэглэл бас цэцэг хуарын товгор дүрстэй хөх тоосгон хавтан олдсон нь барилгын дээврийн дэлийг чимэглэж байсан бололтой. Хэв загвар, янз маяг нь Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын Хэрлэн Барс-1 хотын хэрмийн доторх чулуун өрлөгт барилгын үлдэгдэл (Пэрлээ 1957: 119-133, Таб. 14), Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутаг Сүмтийн тойрмын турийг (Баяр нар 1995: 211-212) малтлагаас гарсан барилгын чимэглэлтэй тун төстэй. Түүний зэрэгцээ хаалганы дээд талын дээврийн нүүрэн талыг чимэглэж байсан зээ бадын дүрстэй нүүр ваар, цэцэг ургамлын дүрстэй үзүүрийн чимэглэлийн хагархай хэсгүүд урд ханын нурангийг малтахад олдсон. Энэ байдлаас үзэхэд хаалга байрлаж байсан урд хана нөгөө гурван ханыг бодоход олон төрлийн шавар чимэглэл чулуун өрлөгийн нь завсар хавчуулж барьсан, хатавчны мод өмхрөн унахад хана тэр чигээрээ нурж өрлөг нь эвдэрсэн мэт байна. Хожим эндээс барилгын нурангид байсан чулуун материал, тоосго, бусад зүйлийг хүмүүс авч зөөсөөр байсан нь тодорхой. Тухайлбал, үүнийг бичигч 1991 оны намар ШУА-ийн Түүхийн

хүрээлэнгийн “Дорнод Монголын экспедицид” ажиллах үеэр нутгийн өвгөн Дугаржавын Самбанүрдэв агсан, мянган жил болсон хөх тоосго эмийн найрлаганд ордог гэж Довжооноос тоосго авдаг тухай хуучлан ярьж байж билээ.

Довжоо-1-ийн туриас дээврийн ваарны хагархай харьцангуй цөөхөн олдсон, бүтэн хадгалагдсан тоосго бараг байсангүй. Нэг хөх тоосгон ваарны хагархай дээр нэвт цоолж төмөр хадаасаар дээврийн модонд хадаж байсан ул мөр - нүхэнд нь зэвтэй хадаасны хугархай тэр чигээрээ шаалттай хэвээр хадгалагдан үлдсэн байв. Дээврийн ваарны тоо хэмжээ, модон хийцийн олдвор маш бага буйгаас үзэхэд уг барилга олон давхарлиг бус, харин хялбар дөхмийг бодолцсон энгийн дан дээвэртэй байсан бололтой.

Хаалганаас ямар нэг зүйл хадгалагдаж үлдсэнгүй. Харин урд ханын өрлөгийн төв хэсгээс ховил гаргаж зассан 13 см өндөр, 12,5 см өргөн хэмжээтэй засмал боржин чулууны хугархай олдсоныг хаалганы босго мэт зүйлд ашиглаж байсан болов уу гэж үзэж болохоор байна. Түүний дэргэдээс өрлөгийн чулуу болон хөх тоосгоны хагархай, шаваасны хагархай холилдсон нуранги дундаас түүхий шавраар хийсэн, алтлаг шар өнгөөр будсан бурханы хөлийн хурууны хэсэг олдсон. Эндээс модны үлдэгдэл маш бага гарсан. Жижиг төмөр хадаас 9 ш, малын ясан эвэр 1 ш, мөн бурхан багшийн шавраар хийсэн үснэр 1 ш нэмж олдов.

Урд ханын малтлагаас үзэхэд тэнд засмал чулуун босготой жижгэвтэр модон хаалга байжээ. Хаалганы хатавч ба тотгоны захыг хоёр талдаа бадам цэцгийн дэлбээ, үрлэн хээг товойлгосон чимэглэлийн тоосгоор эмжиж ханыг нь чулуу болон хөх тоосгоор өрж байсан бололтой. Гэвч хөх тоосгоны чанар сайн байсангүй. Урд ханын өрлөг бүхэлдээ нурж эвдэрсэн бөгөөд нурангийг цэвэрлэхэд анхны байрандаа үлдсэн өрлөг гараагүй. Энэ ханын нурангиас барилгын дээврийн хажуу дэлийг чимэглэж байсан бололтой цэцэг хуарын дүрстэй хөх тоосгон хавтан, дээврийн төгсгөлийн эр, эм ваарны тольт олдсоноос үзэхэд тус жижиг барилгын зөвхөн урд нүүрэн хэсгийг гоёмсог чимэглэж байсан бололтой.

Барилгын хойд хана: Хавтгай чулууг 6-9 үе давхарлан өрж завсар зайг нь үнстэй хольсон саарал шавраар чигжиж шаварджээ. Ханын үлдэгдэл хамгийн нам хэсэгтээ 60 см, өндөр хэсэгтээ 85 см (Зураг 4).

Барилгын баруун хана: Мөн ижил хийцтэй. Хадгалагдсан өрлөг 4-7 давхар, 60-75 см өндөр (Зураг 5).

Барилгын зүүн хана: Хадгалагдсан өрлөг 5-6 давхар, 55-70 см өндөр (Зураг 6).

Урд ханын өрлөг бүтэн хадгалагдаагүй боловч баруун, зүүн ханатай залгагдаж байсан ормоос нь үзэхэд 65-70 см зузаан байжээ. Барилгын тасалгааны дотор талын ханыг бүхэлд нь шар шавраар 2-5 см зузаан шавардаж байжээ.

Хаалганы өргөн болон хэмжээг тогтоох баримт үлдээгүй.

Барилгын шалан дээр тоосго, эсвэл чулуу дэвсээгүй, мөн мод, банзаар шаллаагүй. Харин нимгэн шавар зуурмаг түрхэж тэгшилсэн байжээ. Тасалгааны зүүн урд буланд дагтаршуулсан шавар шалыг нүхлэн орсон мэрэгчийн нүхэнд мэдэгдэж буй шалны зузаан 1 см.

Бид барилгын дотор тасалгааны хойд, баруун, зүүн ханын өрлөг, дагтаршуулсан шалыг ил гарган, урд ханын нурангийг бүрэн цэвэрлэж баримтжуулсны дараа тасалгааны зүүн хойд хэсэгт шалнаас доош хэсэг газар цөмлөн ухсан тонуулчдын нүхийг цэвэрлэж шалгав. Тэгэх явцад барилгын суурийг хэрхэн байгуулсныг мэдэх бололцоо олдов.

“ДОВЖОО-1” ХЭМЭЭХ ДУРСГАЛЫН ТУХАЙ

Ерөөс энэхүү жижиг барилга төдийгүй нийт Сүмийн довжооны дөрвөлжин суурийн тавцанг байгалийн боржин чулуугаар 4-5 үе давхарлан шороо шавраар чигжин бэхжүүлж байгуулсан ажээ. Тэгээд барилга барих хэсгийн суурийг шавар зуурмаг, шороогоор бага зэрэг тэгшлэн бэлтгээд дээрээс нь дахин шавар зуурмаг нимгэн түрхэж шал тавьдаг байсан аж.

Барилгын тавцан суурийн зохион байгуулалт. Бид Довжоо-1-ийн баруун хойд буланд байсан жижиг барилгын тасалгааны зүүн хойд буланд шалыг цөмлөсөн тонуулчдын нүхийг цэвэрлэн шалны түвшнээс доош 70 см гүн малтахад:

- Шавар зуурмаг түрхэж тэгшилсэн шал 2,5 см зузаан
- Түүнээс доош 2,5 см зузаан бараан өнгөтэй шороон хөрс
- Түүнээс доош 4 см зузаан цагаан шаргал өнгийн шавар зуурмаг
- Түүнээс доош 2,5 см зузаан бараан өнгөтэй шороон хөрс
- Түүний доор суурийн боржин чулуун бэхэлгээний дээд талын чулуунд тулав.

Боржин чулуугаар нийтдээ 5 үе давхарлан өрсөн бөгөөд эмх замбараагүй тавьсан бус тавцанг бат бэх болгохын тулд нэгийг нөгөөгөөр даруулан завсар нь шороо дүүргэж хийсэн ажээ. Энэ арга нь Монгол, Төв Ази, Умард Хятадад дундад зууны үед ихэд дэлгэрсэн элс, шавар, хайргаар олон үе дагтаршуулан дэлдэж барилгын суурь тавьдаг эртний хятадаас гаралтай “ханту” хэмээх техникээс ялгаатай, тухайн орон нутгийн онцлогийг хадгалсан гэж үзүүштэй байна. Тонуулчдын нүхнээс ямар нэг олдвор гараагүй.

Бид барилгын тасалгааны дотор талыг бүрэн малтаж цэвэрлэн баримтжуулсны дараа чулуун барилгын гадна талын ханын зүүн, баруун, хойд талд буй чулуу шорооны нурангийг малталгүй орхив. Учир нь ажлын төлөвлөсөн цаг хугацааны зэрэгцээ барилгын үлдэгдлийг дөрвөн талаас нь бүрэн цэвэрлэж малтахад хана эвдэрч нурах аюултайг харгалзан үзсэн болно. Малтлагын дэвсгэр зургийг дрон ашиглан фотограмметрийн аргаар баримтжуулсан.

Довжоо-1 дээр бидний сорилтын малталт хийсэн жижиг барилга нь суурийнхаа хамт ойролцоо цаг үед баригдсан бөгөөд хоорондоо он цагийн хувьд ялгаатай олон соёлт давхарга байхгүй, барилгын нуранги нь бүхэлдээ нэг л цаг үеийнх болно.

ОЛДВОРЫН ТОДОРХОЙЛОЛТ

Барилгын материалын зүйл:

Нүүр ваар буюу төгсгөлийн эр ваарны тольт. Дугуй хэлбэртэй. Зээ бадын дүрстэй. Зээ бад нь монцгор хамартай, дугуй нүдтэй, амыг нэг зураасаар хөндлөн гаргаж тэр зураасан дээр олон зэрэгцээ босоо зураасаар арзайсан шүд дүрсэлсэн. Хоёр хацар дээр нь тус бүр зэрэгцээ шугамаар товгор зураас гаргаж дүрсэлсэн (Зураг 7). Голч 11 см. Зузаан 1,7 см. Үзүүрийн нүүр вааран дээр шавраар залган нааж тогтоож байсан ором ард нь бий. Бараг бүтэн шахуу 1, тал хагархай 1, арзгар шүдний дүрстэй хагархай 1, нийт 3 ш олдсон.

Төгсгөлийн эм ваарны тольт. Нүүрэн талд хоёр тийшээ тэгш хэмтэй салаалсан хос навч бүхий урт иштэй дөрвөн дэлбээтэй, дөрвөн нахиа голлосон цэцэг дүрсэлсэн (Зураг 8). Хэмжээ: 17 см өргөн, 8 см өндөр, 2,7 см зузаан. Бүтэн 1, хагархай 4 ш, нийт 5 ш олдсон. Зарим хагархай дээр улаан будагны ором бий.

Нөмрөг буюу эр ваар. Шавраар хэвлэж хутгаар өө сэвийг нь толийлгон засаж шатааж бэхжүүлсэн. 14,8 см өргөн, 1,5-2,2 см зузаан. Залгаасны тагнай 2 см урт.

Тосгуур буюу эм ваар. Шавраар хэвлэж шатааж бэхжүүлсэн. Ардаа бүдүүн ширхэгтэй даавууны оромтой. 1,4 см зузаан.

Хөх тоосго. Шавраар хэвэнд цохиж шатааж бэхжүүлсэн. Гонзгой дөрвөлжин хэлбэртэй. Бүтэн тоосго олноогүй, дандаа тал, эсвэл хагархай гарсан. Тоосгоны хагархайгаар үзэхэд ерөнхийдөө гурван янз байна. Нэг нь 14 см өргөн, 6 см зузаан. Арай том нь 15 см өргөн, 7 см зузаан болно. Энэ хоёр чанарын хувьд гурав дахиас арай илүү. Гурав дахь төрлийн тоосго 16 см өргөн, 8 см зузаан. Хөнгөн боловч хэврэг бутрамтгай. Бодвол шатаалтын горим алдагдаж хэт шатаасан бололтой. Дотор тал нь шатсан үнс, тогооны хөө мэт хар өнгөтэй болжээ.

Дээврийн дэлний чимэглэлийн тоосгон хавтан. Шавраар хэвэнд цохиж шатааж бэхжүүлсэн. Хавтгай дөрвөлжин хэлбэртэй. Нүүрэн талд нь долгиолсон урт иштэй мандарваа цэцгийг тэгш хэмтэй товойлгон дүрсэлсэн (Зураг 9). Бүтэн хадгалагдсан нэг ч хавтан олноогүй. Гэвч хэд хэдэн ийм хавтанг залгаж барилгын дээврийн ноён нуруун дээрх дэл буюу сэрвээг чимэглэж байсан нь тодорхой. Хавтангийн ар талд хооронд нь 13 см зайтай тус бүр 11 см өндөр, 5 см өргөн газар өрлөгийн завсар оруулж шавардан тогтоох зориулалттай тусгай шаантаг маягийн зүйлийг шавраар хийж нааж байсан нь зарим хавтангийн хагархайд хэвээр хадгалагдан үлджээ. Хавтангийн өндөр 14 см, зузаан 2-2,5 см.

Чимэглэлийн тоосго. Шавраар хэвэнд цохиж шатааж бэхжүүлсэн. Гонзгой дөрвөлжин хэлбэртэй. Тоосго урталжин хоёр хажуу талын нүүрэндээ бадма цэцгийн дэлбээ ба түүний доогуур дугуй үрлэн хээг тэгш хэмтэй товойлгосон давтсан дүрслэлтэй (Зураг 10). Тоосго Хэмжээ: 22 см урт, 13-14 см өргөн, 7,5 см зузаан. Зарим тоосгоны хээтэй талд улаан будгаар будаж байсан ором мэдэгдэнэ.

Шавар чимэглэлийн хэсэг. Шавраар хийж шатаасан баримлын хэсэг. Дээврийн чимэглэлийн хэсэг бололтой. Хар саарал өнгөтэй, шаталт сайн. Хүний гар, амьтны хошуу мэт хэлбэртэй хоёр хугархай олдсон. Хадгалагдсан хэмжээ: 14 x 11 x 8 см; 11 x 9,5 x 4,5 см.

Будагтай шаваас. Шар шавар. 1,5-2 см орчим ирмэг гаргаж шавсан ханын шаваасын үлдэгдэл. Улаан, ногоон өнгөөр будсан оромтой. Зарим хагархай дээрх улаан будган дээр алтан боронзоор зураг зурж байсан ул мөр мэдэгдэнэ. Шаваас 2-3 см зузаан.

Төмөр хадаас. Урт 3,8 см. Хажуу тийш нь нугалсан богино дэгээ маягийн толгой 1 см өргөн.

Төмөр хадаас. Урт 6,3 см. Хажуу тийш нь нугалсан богино дэгээ маягийн толгой 1 см өргөн.

Тавгүй төмөр хадаас. 8 ширхэг. Урт 4.2-7,5 см. 0,8 см голчтой. Ийм хадаас барилгын хаалга байрлаж байсан урд ханын нурангиас гарсны зэрэгцээ дээврийн ваарны нэг хагархайд нэвт шаасан хугархай нь хамт олдсон. Барилгын дээврийг ваараар хучихад хамгийн урд захын төгсгөлийн даацын ваарыг дээврийн модонд бэхлэж хадаасаар хадаж тогтоодог байна.

Бурхан тахилын холбогдолтой зүйл:

Шавар чимэглэл. Зууван дугуй хэлбэртэй. Хос цагаан зурвас хүрээ гаргаж голын хэсгийг ногоон өнгөөр будаж чимэглэсэн. Хэмжээ: 3x2,3x1,2 см. Шатаагаагүй түүхий шавар.

“ДОВЖОО-1” ХЭМЭЭХ ДУРСГАЛЫН ТУХАЙ

Шавар чимэглэл. Дугуй хэлбэртэй. Цагаан өнгөөр зурвас хүрээ гаргаж, тойргийн голыг улбар цайвар өнгөөр будсан. Голч 1,5 см, зузаан 0,8 см. Шатаагаагүй түүхий шавар.

Үснэр. Бурхан багшийн сэрэг дүрийг шавраар хийхэд үсний ширхэг бүрийг тус тусад нь ороомог маягийн жижиг дүрсээр барьж нааж бүтээсэн байдаг. Довжоон-1-ийн малтлагаас ийм “үснэр” 5 ширхэг олдсон. Түүхий шавраар хийж хар, хөх өнгөөр будсан. Өндөр 1,8-2,2 см. Суурийн голч 1,8-2 см.

Бурханы хөл. Түүхий шавраар хийсэн монцгор бүдүүн хуруутай баруун хөлийн тавхайн хэсэг (Зураг 12). Алтан боронзоор будсан. Хөлийн хумс, хуруу, тавхайн улыг урлагтай сайхан хийсэн. Хадгалагдсан хэмжээ: 11 см урт, 9 см өргөн, 6 см өндөр.

Бурханы баримлын хувцасны хуниасын хэсэг. Түүхий шавраар хийж ногоон будгаар будсан. Хадгалагдсан хэмжээ: 7 x 8 x 3,5 см.

Бурханы чимэг зүүсгэлийн хэсэг. Түүхий шавраар хийсэн. Дугуй хажийг нь улаан будгаар, товойлгосон шигтгээг нь ногоон өнгөөр буджээ. Хадгалагдсан хэмжээ: 4,5 x 2,5 x 1 см. Өөр нэг хагархай байгаа нь 4 x 2,5 x 2 см.

Бурханы баримлын дугуй суурийн хэсгүүд. Түүхий шавраар хийж суурийн доод ирмэгийн 3 см өргөн зурвасыг алтан боронзоор хүрээлэн будсан. Хадгалагдсан хэмжээ: 7 x 3,5 x 6,5 см; 8 x 4 x 2,5 см; 7,5 x 4 x 3,5 см.

Бадамлянхуа сэнтийн дэлбээн хэсгүүд. Түүхий шавраар хийж хундан яагаан өнгийн будгаар будсан. Цэцгийн дэлбээг товойлгон дүрсэлж товгор зурвасыг ногоон будгаар ялган будсан (Зураг 11). Цэцгийн улаан дэлбээг алтан боронзоор будаж гоёсон. Хадгалагдсан хэмжээ: 8 x 4,5 x 1,5 см; 7,5 x 6 x 2,5 см; 7 x 5 x 1 см; 6 x 4 x 1 см.

Сав суулганы зүйл:

Ченхуа хэмээх хөх хуартай хятад шаазангийн хагархай. Амсрын хагархай 5 ш. Бөөрцгийн жижиг хагархай 5 ш (Зураг 13). Аяганы гадна талын амсрын ирмэгээс 0,5 см зайтай тод гүн хөх, түүнтэй зэрэгцүүдэн бүдэг хөх өнгөөр хос зурвас хүрээлж түүний доод талын зайд зураг зурсан. Хадгалагдан үлдсэн жижиг хагархайн хоёр нь эвээрээ нийлж буй хэсэгт үзвэл нисэж буй шувууны дүрс байх мэт. Аяганы дотор талын амсрыг дагуулан 1,3 см зайд дээр нь тод нэг, доор нь бүдэг хос зурвас хүрээ гаргаж тэр хүрээний дотор багтаан хөндлөн чагталсан гурав гурван нарийхан ташуу зураасаар тэгш хэмтэй зурж чимэглэсэн. Амсар 0,4 см нимгэн.

Дин хэмээх цагаан өнгөт шаазангийн хагархай. 1 ш жижиг хагархай олдсон. Дээрээ зураг чимэг байхгүй. 0,4 см зузаан.

Хүрэн паалантай шаазан савны амсар. 1 ш жижиг эмтэрхий олдсон. 0,3 см зузаан.

Ваарны хагархай 5 ширхэг. Хүрэн улаан өнгөтэй, шаврын найрлага нь гадны хольц ихтэй. Болхи хийцтэй, шатаалт муутай. Зузаан 1,2 см.

Бусад зүйл:

Хүрэл товруу. Хөөмөл. Тал бөмбөрцөг хэлбэрийн товгор тавтай. Голч 2 см. Өндөр 1 см. Хээ угалзгүй. Ард нь гагнаж тогтоосон, юман дээр хадаж тогтоох зориулалт бүхий 2 см урт, угаараа 0,5 см, үзүүр нь 0,3 см өргөн, 0,15 см зузаан хадаастай. Яг ижилхэн 2 товруу олдсон.


Төмөр эдлэл. Цутгамал. Дөрвөлжин хэлбэртэй, дугуйрсан булантай. Нүүрэн талд нь голоор нь нэг зурвас гүвгэр гурив гаргаж чимэглэсэн. Хэмжээ: 4,8x6,7x0,3 см. Ямар нэг юмны суурь эсвэл гуу байсан гэмээр зүйл.

Хүрэл зоос. Цутгамал. Дугуй хэлбэртэй. Голч 2,8 см. Зузаан 0,2 см. Зоосны булангаар 0,2 см өргөн зурвас гаргаж хүрээлсэн бөгөөд голдоо 0,8 х 0,8 см дөрвөлжин нүхтэй. Нэг талдаа “Yuan Feng Tong Bao” гэсэн хятад үсэгтэй. Нөгөө талдаа цулгуй (Зураг 14). Энэ нь даруй Умард Сүн (960-1127) улсын Shen Zong (1068-1085) хааны үед холбогдох хятад зоос болно (Hartill 2017: 130-140).

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Тогоотын голын Довжоо-1-ийн малтлагаас гарсан барилгын модны үлдэгдлээс дээж авч (UGAMS-38775) АНУ-ын Жорж Их Сургуулийн Изотопын судалгааны лабораторид он цаг тогтоох шинжилгээ хийлгэхэд дурсгалын үнэмлэхүй насыг 1497 (2.1%) 1506 calAD; 1512 (71.3%) 1601 calAD; 1616 (22.0%) 1646 calAD буюу нийтийн тооллын XVI-XVII зууны хоорондох цаг үед холбогдохыг тогтоож өгөв (Зураг 15). Энэ нь уг барилгын чулуун өрлөгийн хийц, барилгын шавар чимэглэлийн хэв маяг, нэн ялангуяа, тоосгон материалын шатаалт, чанар хир тааруу байсан зэргээр бидний таамаглаж байсан он цагийн баримжаатай ойролцоо дөхөж таарч байна. Өөрөөр хэлбэл, Алтатын хөндий дэх Тогоотын голын Довжоо бол Монгол оронд Бурханы шашин дэлгэрсэн хожуу цаг үеийн дэлгэрлийн түүхэнд холбогдох дурсгал болох ажээ. Энэ үе Түмэдийн Алтан ханы (1507-1582) үеэс эхэлдэг бөгөөд тэрбээр Төвөдийн гэлүгвагийн шашны их хутагт Содномжамцад заллага айлтгаж, улмаар Далай лам цолыг өргөж, Хөх хотын Ширээт зуу тэргүүтнийг бүтээсэн түүхтэй. Мөн үед Халхын Абтай сайн хан (1534-1586) III Далай ламд бараалхаж, улмаар Ар Халхын нутагт Эрдэнэ зуу хийдийг байгуулсан билээ. Энэ цаг үеэс Монгол оронд Бурханы шашин тэр тусмаа гэлүгвагийн шашин машид дэлгэрч, Ар, Өвөр Монголд сүм хийд, хурал номын газар олноор байгуулагдаж эхэлсэн байна. Тогоотын голын Довжооноос олдсон барилгын материалын хийц, чанараас үзэхэд улс төрийн бутралын улмаас үйлдвэрлэх хүчин доройтсон цаг үед холбогдох бөгөөд гаднаас зөөж авчраагүй, тухайн орон нутгийн түүхий эдээр нутгийн урчуул барьсан бололтой.

НОМЗҮЙ

- Баяр Д., Цогтбаатар Б., Гэрэлбадрах Ж., Эрдэнэбат У., 1995. Археологийн судалгаа. – “Монгол-Солонгосын хамтарсан эрдэм шинжилгээ 4”. Сөүл, 185-217.
- Наваан Д., 1970. Мянган дурсгалын эх орон. Улаанбаатар.
- Пэрлээ Х., 1957. Хэрлэн Бар гэдэг эвдэрхий хотыг малтан шинжилсэн тухай. – Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн бүтээл: Нийгмийн ухааны анги. №2. УБ., 119-164.
- Эрдэнэбат У., Батдалай Б., 2019. Дорнод Монголоос шинээр олдсон XVI-XVII зууны Монголын Бурханы шашны сүм хийдийн дурсгал. – “Монголын археологи – 2018” Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Улаанбаатар, 295-301.
- Hartill D., 2017. Cast Chinese Coins: A Historical Catalogue. New Generation Publishing, 482 pages.



Зураг 2. “Довжоо-1” хэмээх дурсгалын ерөнхий байдал



Зураг 3. “Довжоо-1”. 2018 онд малтан шинжилсэн барилгын үлдэгдэл

“ДОВЖОО-1” ХЭМЭЭХ ДУРСГАЛЫН ТУХАЙ



Зураг 4. “Довжсоо-1”. Барилгын хойд ханын үлдэгдэл



Зураг 5. “Довжсоо-1”. Барилгын баруун ханын үлдэгдэл



Зураг 6. “Довжсоо-1”. Барилгын зүүн ханын үлдэгдэл



Зураг 7. Барилгын дээврийн төгсгөлийн эр ваарны тольт буюу нүүр ваар



Зураг 8. Дээврийн төгсгөлийн эм ваарны тольт



Зураг 9. Барилгын дээврийн дэлийг чимэглэж байсан хөх тоосгон хавтан



Зураг 10. Барилгын чимэглэлийн тоосго



Зураг 11. Бадамлянхуа сэнтийн хэсэг – түүхий шавраар хийж будсан




Зураг 12. Шавар бурханы хөлийн хэсэг



Зураг 13. Хөх хууртай шаазангийн хагархай



*Зураг 14. “Юань-фен-тун-бао” хэмээх хятад зоос.
Умард Сүн (960-1127) улсын Шэнзун хааны үе (1068-1085)*



Зураг 15. Радиокарбонь он цаг тогтоох лабораторийн шинжилгээний мэдээ